

“Эзэн миний амьдралыг утга учиртай болгосон”

Шин Бограе итгэгч (Миряан Манмин Сүм)

Урьд нь би ийм аз жаргалыг энэ дэлхий дээр байдаг гэдгийг огт мэддэггүй байлаа. Олон жилийн турш би төрөл бүрийн өвчинд шаналж байсан билээ. 38 настай байхдаа бүхүүн гэдэсний хагалгаанд орсоноос хойш би 27кг хүртэл турж ямар ч эрч хүчгүй болсон ба 2жилийн дараа мөн тархины цус харвалтын улмаас саа өвчнөөр хэвтэрт оров.

Түүний дараахан би эмчийн хяналтад орон тархины нарийн мэс засалд орсноор сул доройт бие минь улам доройтож сульдсан юм. Үүний хажуугар зүрхний өвчин ба үе мөчний үрэвсэлээр хүртэл өвдөж үргэлж тайвшруулах эм, өвчин намдаах эм, хоол боловсруулах гэх мэт олон төрлийн хүчтэй эмүүдийг хэрэглэж байв.

Байдал улам ч дордож миний ганц найдвар минь болж байсан мөн намайг асарч байсан нөхөр минь 2010 оны 8-р сард нас барав. “Амьдарна гэдэг надад үнэхээр хүнд хүчир байна. Би агаад хамт үхсэнгүй вэ?” хэмээн бодогдож тэр цаг үеэс эхлэн амьдрах ямар ч хүсэл алдарч юм ч идэж уулгүй хэвтэн үхэхээ л хүлээж байсан юм. Энэ нь би ч гэсэн нохортгүйг хамт хорвоог орхин одоо хүсэж байсан юм. Тэр

үед бас миний гэдэсний доод хэсгээр үе үе таталдан хөндүүрлэн өвдөж гэдэс минь хөл бөмбөгийн бөмбөг шиг хөөж томорсон юм. Энэ байдал нь бие засахад маш хүндрэлтэй байсан бөгөөд гэртээ би ганцаардал ба сэтгэл санааны хувьд нохилтонд орсон юм. Тэгээд би дотроо, “Байшингаа зараад мөнгийг нь хүүхдүүддээ хувааж өгөөд Пусаны далайд орж живж үхье хэмээн боддог болов.

Тэгтэл 2011 оны Нэгдүгээр сарын эхээр юм. Миний жирийн танил Миряан Манмин Сүмийн Ким Санкуе сүмд үйлчилгэгч надад Доктор И Жаерок пасторын Ухлийн Өмнө Мөнхийн Амьдралыг Амссан нь хэмээх номыг надад бэлэг болгон өгөв. Энэ ном нь түүний амьдралын тухай гэрээллийн ном юм.

Би шөнөдөө ноёр хүрдэггүй учир тэр номыг нь унших болсон юм. Тэр номонд Доктор И Жаерок пастор төрөл бүрийн өвчтэй байсныг болон бүх биенээс нь зөвхөн 2 нүд нь л эрүүл байсан тухай өгүүлж байлаа. Хэдийгээр тийм байсан ч гэсэн тэрээр анх сүмд очин Бурхантай уулзаад өвдөг сөгдөх тэр л агшинд түүний биеийн бүхий л өвчин тэр дороо эдгэрсэн тухай гарч

байлаа. Үүнийг уншаад би өөрийн эрхгүй уйлан сэтгэлийн хөдлөлөө барьж чадахгүй байв. Эцэст нь би ч гэсэн амьд Бурхантай уулзан учрахыг туйлын ихэд хүсэж байлаа.

Нэгдүгээр сарын 9-нд би Миряан Манмин Сүмд бүртгүүлэн орсон ба уг номыг бичсэн Доктор И Жаерок пасторыг бодитоор нь GCN (Global Christian Network)-ын дэлгэцээр харах боломжтой болсонд маш их баяртай байв.Тэрээр сургаал айлдсаныхаа дараа өвчтэй газраа гараа тавина уу гэж айлдсан ба би өвдөж байсан гэдсэн дээрээ гараа тавьж залбирлыг хүлээн авлаа. Залбиралын үеэр миний гэдэс дотор ямар нэгэн юм хөдлөн гүйх шиг болон бага зэрэг өвдсөн юм.

Тэгсэн чинь тэр орой үнэхээр гайхамшигт зүйл тохиолдов. Хөл бөмбөгийн бөмбөг шиг хөөж байсан цүдгэр гэдэс минь ор сураггүй алга болсон байв. Мөн бүх биеийн өвдөлт хөндүүрдүүд минь ариж огт өвдөхгүй байлаа. Түүгээр ч барахгүй, бөөр давсагны үрэвсэл, 30 жилийн турш тийм байсан ч бүгд биелсэн юм . Сүүлийн үед манай сүмд сайн мэдээ тараах хөдөлгөөн явагдаж байгаа болохоор би надай уулзаж өгсөн хайрын Эзэний



засахад хөндүүрлэдэг байсан өвдөлт, болон баруун гарын бугуйн хэсэгт байсан хаан зэрэг бүх биеийн өвчин хөндүүрээ ангижирч төгс эдгэрсэн юм. Халлеуяа!

Одоо би хүссэнээрээ гадаа гарч дасгал хийх болон гүйж харайх болсон билээ. Эзэнтэй уулзсанаараа энэ бүх зүйл мөрөөдөл мэт надад санагдаж төлөө залбирал хийж өгсөн Доктор И Жаерок Тэргүүн пастортаа туйлын ихээр талархаж байна. Тандаа маш их баярлалаа.

Талаар тунхаглаж ,Түүний хайрыг бусдадй хуваалцахын тулд идэвхитэй оролдож байгаа билээ. Миний гэм нүгэлгүй минь уучлан, өвчин зовлонгоос ангижируулсан хайрын Бурхан Аавдаа бидний төлөө загалмайн зовлонг элдэж дахин амлсан Эзэндээ бүхий алдар ба талархал магтаалыг өргөн барья! Хайраараа чин сэтгэлээсээ миний төлөө залбирал хийж өгсөн Доктор И Жаерок Тэргүүн пастортаа туйлын ихээр талархаж байна. Тандаа маш их баярлалаа.

Монгол Үндэсний Их Сургуулийн нэгдүгээр курст байхдаа би Эзэнийг хүлээн авсан юм. Эзэн бидний гэм нүгтийн төлөө загалмайн зовлонг элдэж нас бараад дахин амилж бидний Аврагч Эзэн болсон тухай анх сонсоод сэтгэл их хөдөлж,Түүний хайр энэрэл болон Түүний тухай илүү ихийг мэдэх гэсэн хүсэл миний зүрх сэтгэлээр дүүрэн байлаа.Тухайн үед оюутны цуглаанд явагч байсан бөгөөд хичээлээ тараад цуглаандаа очин Ариун Библийг судлан библийн хичээл хийдэг байсан ба тэр нь надад маш олон зүйлийг мэдэхэд тус болж байлаа. Хэдий тийм боловч надад үл ойлгогдох асуултууд их байсан юм.” Бурхан агаад Еленийн Цэцэрлэгт сайн мууг мэдүүлэгч моныг тавьсан юм бол?”



Тухай гэрчлэлүүдийг үзээд би И Жаерок Тэргүүн пастортай уулзахыг хүсэж байлаа. 2003 оны 11-р сард Оросын Санкт Петербург хотод Доктор И Жаерок пасторын Эдгэрлийн нэгдсэн их цуглаан явагдах гэж байгааг сонсоод би Монгол Манмин Сүмийн номлогчтой хамт тэр цуглаанд оролцохоор явав. Тэнд очиход нэгдсэн их цуглааны байранд маш олон хүн цугларсан байсан ба Доктор И Жаерок пастор тэдгээр хүмүүст хандан “агааад Есүс Христ бидний аврагч болсон б” гэсэн сургаал айлдаж түүний дараа эдгэрлийн залбиралыг үйлдэв. Маш олон хүмүүс өвчнөөсөө эдгэрсэн тухайгаа гэрчилгээг үзсэн болон миний сэтгэл ихэд хөдлөн анхандаа үнэхээр их гайхаж байлаа . Олон мянган хүмүүс өвчнөөсөө эдгэрч, хөл муутай доголлон хүмүүс түрдэг тэрэг болон таягаа чулуулан хаяж байгаа болон хараагүй хүн хараа орж, дулийн хүн сонсолтой болж, мөн төрөл бүрийн өвчин хөндүүр ариллаа эдгэрлээ гэхийг хараад бидний Бурхан Аав ямар агуу болохыг мэдсэн юм. Мөн бас нэг мартагдашгүй үйл явдал бол Монголоос Доктор И Жаерок пастортай биеэрээ уулзахыг хүссэн хүсэл минь биелж И Жаерок пасторын

“Ерөөлт ариун сайн мэдээг Монгол улсдаа өргөнөөр түгээн тунхаглая”

Ганбаатар Анхбаяр (Гадаад итгэгчдийн бүлэг, Монгол)

дөлгөөхөн инээмсэглэл ба анх удаа гар барьсан тэр сэтгэл хөдлөм мөчийг мартахагн аргагүй юм. Энэхүү үйл явдал ба эдгэрлийн гайхамшигт үйлдүүд миний итгэлээр өсөн бэхжихэд маань асар их тус нэмэр болсон юм.

Түүний дараа 2004 оны Арванхоёрдугаар сард би итгэлийн сорилттой тулгарав. Би хөнгөн ханиад туссан бөгөөд тэр нь хүндээр цустай цэр хүртэл гарч ханиалган халуурч байлаа. Ээж маань эмч тул намайг үзээд эм уу, хэвдэ тариа хийлгэ эс тэгвэл ханиад улам хүндээр болзошгүй хэмээн хэлж байсан юм. Хэдий тийм ч гэсэн би итгэлээрээ эдгэрхийг үзэв. Доктор И Жаерок пасторын сургаалыг сонсож түүний дараа гардаг өвчнийн төлөөх залбирлыг итгэлээрээ хүлээн авлаа. Тэгтэл миний хамаг бие халуу төвөнөн хөлс асарч эхлэв. Тэгээд би бүрэн эдгэрсэн юм. Энэ цаг үеэс эхлэн авсан хайр ба нэрэл нээлийг хариулах сэтгэлээр сүмийн үйлчлэл ба сайн мэдээ тараах үйлээд зүтгэж эхэлсэн юм. Өдөр өнгөрөх тусам Манмин Төв Сүм дээр очихыг ихэд хүсэн тэмүүлэн итгээд өсгөн Бурханы үг сургаалуудыг шимтгэн судлан сургаад эх орондоо энэ хүчиг үг сургаал ерөөлт

ариун сайн мэдээг тунхаглахыг туйлын ихэд хүсэн залбирлаар бэлтгэж байлаа. Ингэсний эцэст би залбирлын харууг хүртэн мөн И Жаерок Тэргүүн пасторын залбирлын ачаар 2008 оны Хоёрдугаар сард би Солонгост хүрч ирэв. Учир нь Солонгос явахад саадгүй байхын төлөө И Жаерок Тэргүүн пасторын залбирлын хүсэлт илгээсэн тэрчлэн ёсоор болсон юм. 2009 онд Доктор И Жаерок пасторын айлдсан Тамын талаарх цуврал сургалыг сонсоод энэ үнэний үг сургаалыг Монгол газарт өргөнөөр түгээн тунхаглах хүсэл минь улам эрч хүчтэй болж олон хүмүүсийг Бурханы үгээр аврал руу удирдаж энэ аймшигтай тамын тухай мэдүүлэхийн тулд эрчимтэй бэлдэж эхлэв. ММБТ (МанМин Миссионер Бэлтгэх Төв)-н 20дахь ээлжийн сургалтад хамрагдан сургаал үгийн бэлтгэл хийж . Би MIS (Манмин олон улсын библийн Сургууль) –р дамжуулан “Загалмайн Үг”, “Итгэлийн Хэмжээ” ба “Сүнс, Сэтгэл Бие” хэмээх сургаалуудаар болон өөр олон чухал сургаалуудыг судалж

Mongolian

Манмин Мэдээ
Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Севл,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин

Манмин Мэдээ

Манмин Телевиз нь Дэлхийн Христийн Телевизийн Сүлжээнд нэгдэн хамтын үйл ажиллагаагаа өргөжүүлэлээ.

68-дахь удаагын NRB Үзэсгэлэн Яармаг болон 12-р ФИСАП-ын Олон Улсын Кабелийн нэвтрүүлгийн холбооны үзэсгэлэн яармагт амжилттай оролцлоо.

Манмин төв сүм нь телевизийн нэвтрүүлгээр дамжуулан сайн мэдээг эрчимтэй түгээж байгаа билээ. Хоёрдугаар сарын 26-наас Гуравдугаар сарын 1-ны хооронд Манмин ТВ нь Америкийн Нэгдсэн Улсын Теннесси мужийн Нашвилли хотын Үзэсгэлэн Яармагын танхимд болсон 2011 оны 68-дахь удаагын дэлхийн Христийн телевизийн төвүүдийн чуулган болон сурталчилгааны олон улсын фестивалд манай сүмийн Манмин ТВ нь оролцож тус телевизийн төвүүдтэй нэгдэн үйл ажиллагаагаа улам өргөжүүлэн явуулахаар боллоо.

Хоёрдугаар сарын 26-нд, Манмин ТВ нь олон улсын хүлээн авалт болон NRB-ийн нэгдсэн чуулган нээлтийн үйл ажиллагаанд оролцсон юм Мөн 27-ний өдөр NRB үзэсгэлэн яармагт оролцлоо. Энэ удаагын үзэсгэлэн яармагт Дэлхийн өнцөг тулан бүрээс христийн телевизүүдийг төлөөлж 6 мянга гаруй сэтгүүлч, сурвалжлагч нар хүрэлцэн ирсэн ба 200 орчим холбогдох олон нийтийн байгууллагууд оролцсон юм. Мөн түүнцлэн, Америкийн Нэгдсэн Улсын Төлөөлөгчдийн тахимын тэргүүдэгч Жонн Андрейв Бохнер Телевизийн удирдах ажилтнуудын хэвлэл мэдээллийн албаны хүндэтгэлийн оройн зоогон дээр хүрэлцэн ирж үг хэлэв.

Энэ удаагын үйл ажиллагааны үеэр өргөн дэлгэцийн HD хэлбэрээр маш өндөр түвшинд бүтээгдсэн Доктор И Жаерок пасторын Эхлэл бүлгийн тайлбар сургаал дундаас 4-н цуврал бүхий Амийн Үр сургаал , мөн Доктор И Жаерок пасторын 2010 онд Естони улсад хийсэн нэгдсэн их цуглааны үйл ажиллагаа болон Манмин Төв Сүмийн 28-н жилийн ойн баярын үйл ажиллагаа “Тэнгэрийн орны Шинэ Иерусалим дахь далайн эрэг дээрх найр” гэх зэрэг сэдэвт бүтээлүүдээр оролцож, Доктор И Жаерок пасторын мөн олон орны хэл дээр орчуулагдан гарсан итгэлийн амьдралын тухай өгүүлсэн номууд ба Мүан амгат ус тус үзэсгэлэн яармагт оролцсон бөгөөд хүрэлцэн ирсэдийн анхаарлыг маш их гатаж байлаа.

Мөн Манмин ТВ-н сурталчилгааны талбайд олон өндөр дээд шатны хүмүүс хүрэлцэн ирсэн юм. Тэр дундаас NRB -гын ерөнхийлөгч Доктор Франк Врайт эрхэм хүрэлцэн ирэн өнгөрсөн жил манай сүм дээр айлчлан ирэх үед түүнийг эелдэг



■ 68-дахь удаагын NRB Үзэсгэлэн яармагт оролцож буй Манмин ТВ-ын танилцуулгын танхим (Фото зураг 1) ■ Манмин ТВ-ын Ерөнхийлөгч Боаз Лее гуай ФИСАП-ын ерөнхийлөгч Естреплита Жулиано Таманогоос талархалын цом хүртэж байгаа нь (Фото зураг 2) ■ NRB -гын ерөнхийлөгч Доктор Франк Врайт (Фото зураг 3) ■ NRB «Ухлийн Өмнө Мөнхийн Амьдралыг Амссан нь» номыг үзүүлж байгаа нь (Фото зураг 4) ■ Манмин ТВ Өмнөд Африкийн TWR радиотай гэрээ хийж байгаа байдал (Фото 5) ■ COICOM (Испани хэл дээрх нэгдсэн христийн нэвтрүүлгийн төв) ерөнхийлөгч Арнолд Эннс (Фото 6) ■ Манмин ТВ-ын ажилтан үзэгчдэд сүмийн тухай танилцуулж байгаа байдал (Фото зураг 7)

халуун дотноор утган хүлээж авч байсан итгэгч нар болон бүх итгэлийн ах дүүсдээ гүн талархалын халуун мэндийг дамжуулсан юм. Мөн түүний нарийн бичиг болох Линда Смит гуай хэлэхдээ” Доктор И Жаерок пасторын номуудыг уншаад итгэл минь улам бэх бэх боллоо” хэмээн дурдан хэлж байлаа.

Үүнээс гадна CCC-гын үндэслэгч Доктор Билл Врайт гуайн эхнэр Воннет Врайт, мөн Америкийн ANS -ын Тэргүүн, Дан Воудинг сэтгүүлч , COICOM (Испани хэл дээрх нэгдсэн христийн нэвтрүүлгийн төв)-н ерөнхийлөгч Арнолд Эннс, CNL Телевизийн ерөнхийлөгч Максис Максимов ба “Ин Виктори” Сэтгүүлийн үндэслэгч Сергей, түүний эхнэр Наташа Велбовет нар хүрэлцэн

иршээв. Мөн Доктор И Жаерок пасторын сургаалыг Орос даяар нэвтрүүлдэг ТВН телевизийн захирал Игор Никитин пастор хүрэлцэн ирсэн юм.Тэрээр хэлэхдээ” олон хүмүүс Доктор И Жаерок пасторын сургаалыг нэвтрүүлгээр дамжуулан үзэж, Эзэн Есүсийг өөрсдийн амьдралдаа хүлээн авч мөн эдгэрч байна” гэсэн бөгөөд үзэгчдээс маш олон захидал болон e-мейл, утсаар тэдний гэрчлэлүүд ирээр байна хэмээн хэлэв.

Манмин ТВ нь энэ удаагын үзэсгэлэн яармагаар дамжуулан Манмин Төв Сүмийн нэвтрүүлгээр авралын зар түгээх үйл ажиллагаа нь хэрхэн эрч хүч идэвхтэй явагдаж байгааг харсан бөгөөд цаашлаад дэлхийн даяар христийн нэвтрүүлгийн

сүлжээнд нэгдэн олон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллахаахыг зорилтоо болгосон юм. Америкийн “Пераблес ТВ”, “КАХЛ ТВ”, “КСАН Радио” болон Илондсейын “Ю ченнал” болон Ираны “Нетворк 7 ТВ”, Английн Гари Викинсон Хэвлэл Мэдээллийн алба болон Германы Олон улсын Провизион төв гэх зэрэг 7 орны 12 Христийн телевизүүд хэвлэл мэдээллийн албадтай хамтран ажиллаж гэрээнд гарын үсэг зурсан юм.

Ираны “Нетворк 7 ТВ”-н захирал Мани Ирфан,” Ойрхи Дорнодын улсуудад Эзэнийг ивээл ба эрх мэдэлт хүч үйлс маш их хэрэгтэй билээ. Ариун сайн мэдээ ба энэ эрх мэдэлт хүчигт зүйлс бүхий Манмины үйл ажиллагаа нь тус бүс нутагт маш их

нөлөө үзүүлдэг гэдэгт итгэлтэй байна хэмээн дурдан хэлсэн юм. Гуравдугаар сарын 1-нээс Гуравдугаар сарын 5-нд, Манмин ТВ нь Филиппин улсын Манила хотноо FICAP (Филиппин улсын Олон Улсын Кабелийн телевизийн холбоо)-ны үйл ажиллагаанд оролцсон юм. Энэ удаагын үйл ажиллагаанд Манмин ТВ нь 15-н хэвлэл мэдээллийн телевизүүд хэвлэл мэдээллийн албадтай хамтран ажиллаж гэрээнд гарын үсэг зурсан юм.

Манмин ТВ нь GCN сувгаар дамжуулан өргөн хэмжээгээр ариун сайн мэдээ болон Бурханы эрх мэдэлт хүчигт дэлхийн олон орноо нийлүүх эрч хүчтэй тунхаглан тарааж байгаа билээ.

“Загалмайн Сайн Мэдээ” Цувралууд --(10)

Өнө эртнээс далдлагдсан нууц

“Бид төлөвшсөн хүмүүсийн дунд мэргэн ухааныг ярьдаг. Ингэхдээ энэ үеийн мэргэн ухааныг бус, өнгөрөн одож буй энэ үеийн удирдагчдын мэргэн ухааныг ч бус, харин нууц дотор буй Бурханы мэргэн ухааныг бид ярьдаг. Энэ нь бидний алдрын төлөө үеүдээс ч өмнө Бурханы урьдаас тогтоосон нуугдмал мэргэн ухаан мөн” (1 Коринт 2:6-7).

Бурханы хүү Есүс Христ нь энэ дэлхий дээр махан биеийг өмсөн ирээд ямар ч гэм нүгэлгүй боловч загалмайн дээр цовдлогдон нас барсан билээ. Энэ нь гэм нүгэлт хүн төрөлхтөнийг аврахын төлөө Бурханы хүсэл ба агуу төлөвлөгөөт үйл ажиллагаа байсан юм. Тиймээс, хэн ч гэсэн Есүс Христийг хүлээн авбал бүхий л гэм нүглээсээ уучлагдан аврал хүртэх төдийгүй Бурханы хүүхдийн эрх мэдэл ба ерөөлт амьдралаар амьдрах болно.

1. Өнө эртнээс өмнө Хүн Төрөлхтөнийг аврах арга зам

Бурхан энэ дэлхийн гэм нүгэлт бүх хүн төрөлхтөнийг аврах төлөвлөгөө өнө эртнээс төлөвлөж тохиромжтой цаг нь ирэх хүртэл чанд нууцлан хадгалж байв. (1Коринт 2:7) Тэгвэл Бурханы өнө эртнээс чанд нууцлаж байсан авралын нууц нь юу юм бол?

Адам Ева хоёр могойн уруу таталтанд орон сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идэн хараал хүртэх үед Бурхан Хүн төрөлхтөний авралын тухай зөгнөсөн юм. Эхлэл 3:15-д, “Би чамайг тэр эмэгтэйтэй өс хонзонтой, Бас чиний үр хүүхдийг тэр эмэгтэйн үр хүүхэдтэй өс хонзонтой болгох болно. Тэр эмэгтэйн үр хүүхэд чиний толгойг няалж, чи түүний өсгийг няцлах болно” хэмээн айлдсан байдаг. Сүнслэг ойлголтоор бол “эмэгтэй” хэмээн хэлж байгаа нь Израйлыг төлөөлөн хэлж байгаа ба “ эмэгтэйн үр хүүхэд ” гэдэг нь бүх Израйлчуудын дунд ирж Есүс Христийг төлөөлөн хэлж байгаа юм (Илчлэлт 12:5).

Үүнчлэн Бурхан Израйлаас дайсан муу ёрын сүнс сатаны эрх хүч чадлыг устгаж хүн төрөлхтөний аврах Есүс төрөн гарч загалмайд дээр цовдуулан үхэх тухай зөгнөн айлдсан байдаг. Ийм учраас өстөн дайсан муу ёрын сүнс сатан нь хожим ирэх Аврагч Эзэнийг улайран хайж алахыг оролддог байв.

Эцэст нь 2000 -иад жилийн өмнө Есүс Израйлын Бетлехем хотод төрж, дайсан муу ёрын сүнс сатан тэр үед Израйлыг захирч байсан Херод хааныг удирдаж Есүсийг устгахаар оролдож байсан юм.Тиймд Бурхан Есүсийг өсгөсөн энэг болох Иосефын зүүдэнд хүрч ирэн Есүсийг аван Египет руу зугтахыг сануулдаг ба түүний дараа ч гэсэн дайсан муу ёрын сүнс сатан нь фарисейчууд болон ахлах тахилчид нар мөн атгаг хүмүүсүүдийг ашиглан Есүсийг эсэргэцүүлж алах гэж оролдож байсан ч Бурхан Түүнийг үргэлж хамгаалж байлаа.

Тэгээд цаг нь болоход Есүс атгаг хүмүүст баригдан нүд халтирам маш харгис хэрцгийгээр тамлагдан загалмайн дээр нас бардаг. Дайсан муу ёрын сүнс сатан нь Есүсийн үхлээр дамжуулан бүх зүйл шийдэгдэж ялалт байгуулаа гэж бодож байсан ч Бурханы гайхамшигт нууц яг энд л байгааг тэр мэдээгүй билээ.Ямар ч гэм нүгэлгүй Есүсийг хорлон алснаас болж өстөн дайсан муу ёрын сүнс сатан нь харин ч өөрөө Бурханы гайхамшигт нууц төлөвлөгөөг биелүүлэхэд тус болох хэрэгслүүр болж хувирсан билээ.

2. Есүсийг загалмайд цовдолж Сүнслэг ертөнцийн хуулийг зөрчсөн муу ёрын сүнс

Ромын 6:23-д, “Нүглийн хөлс бус үхэл” хэмээн айлдсан байдаг шиг сүнслэг ертөнцийн хуулиар бол үхэл гэдэг шийтгэл нь гэм нүгэлт хүмүүст л хамаарагдах учир гэм нүгэлгүй хүнд үхэх шийтгэл огт хамаарагдахгүй юм. Тэгтэл дайсан муу ёрын сүнс нь огт гэм нүгэлгүй Есүсийг хорлон алснаараа сүнслэг ертөнцийн хуулийг зөрчсөн тул хууль зөрчсөн учраас өөрийн эрх мэдлээ, тодруулбал хүнийг удирдаж үхэл рүү хөтөлдөг эрх мэдэл хүээ алдахаас өөр аргагүй байдалд орсон юм.

Огт гэм нүгэлгүй байсан Есүс эцгийгээр загалмайн дээр цовдлогдон үхсэн ч гэсэн Тэрээр үхлийн эрх мэдлийн ялан дийлж дахин амилсан юм. Тиймээс хэн ч загалмай дээр



Доктор И Жаерок Тэргүүн Пастор

цовдлогдон нас барж дахин амилсан Эзэнд итгэвэл дайсан сатаны үхлийн эрх мэдэл хүчнээс чөлөөлөгдөж, Тэнгэрийн орон руу орох боломжтой болж (Ром 5:18-19) эмэгтэйн үр хүүхэд могойн бяцална гэдэг Эхлэл номын зөгнөл төгс биелснийг харж болно.

Хэрэв дайсан муу ёрын сүнс энэхүү загалмайн нууцыг мэдэж байсан бол эвсэнь нь Есүсийг барьж алахгүй байх байсан билээ (1 Коринт 2:8-9). Бурханы нэгэн хэсэг болох Есүсийн хувьд энэ төлөвлөгөөг мэдэж байсан бөгөөд Бурханы хүсэлд төгс дуулавартайгаар даган үхлийг туулан үүгээр дамжуулан авралын төлөвлөгөөг төгс биелүүлсэн юм. Тиймээс, Ром 10:10-д, “Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ” хэмээн айлдсанчлан хэн ч гэсэн итгэлээрээ Эзэнтэй нэг болвол Бурханы ивээлээр авралыг олох юм.

3. Дахин амилсан Есүстэй итгэлээр нэгдэх

Бид нар итгэлээр Эзэнтэй нэгдэнэ гэдэг нь юу гэсэн үг вэ? Иоханы 6:56-д Есүс, “Миний махыг идэж, цусыг уусан хүн Миний дотор байж,Би ч түүний дотор оршин байна” хэмээн айлдсан байдаг. Түүний махыг идэж цусыг нь ууна гэдэг нь биднийг Эзэний үг сургаалыг өөрийн болгон авч, үйлсээр сахин хэрэгжүүлэх итгэлээ үзүүлэх юм. Тэр л үед бид Эзэний дотор оршин Эзэн бидний дунд орших юм.

Мэдэж, Эзэнийг хүлээж аваад шууд тэр даруй сургаал үгний дагуу амьдрах нь тийм ч амаргүй байдаг. Хэдий тийм ч гэсэн, Бурханы үг сургаалын дагуу амьдрах гэж зүтгэж буй хүний зүрх сэтгэлтэй нь Бурхан хараал энэ үйлсийг итгэл гэж хүлээн зөвшөөрөдг билээ. Тиймээс Бурханы үг сургаалын дотор амьдарч Эзэнийг дуурайх явдал нь Эзэнтэй итгэлээр нэг болно гэсэн үг юм.

1 Иоханы 1:7-д, “Харин Тэр Өөрөө гэрлийн дотор байдагчлан бид гэрлийн дотор явбал, бид бие биетэйгээ нөхөрлөж, Түүний Хүү Есүсийн цус биднийг бүх нүглээс цэвэрлэдэг ажээ.” гэж айлдсанчлан бидний бүхий л үйлс гэрэл бүхий Бурханы үгэн дотор үйлдэгдэх үед Есүсийн цус биднийг бүх гэм нүглээс ариусган цэвэрлэдэг билээ. Тэгээд бид Эзэн дахин амилсан шиг бид ч тэр дахин амилалтын алдрыг хуваалцан мөнхийн тэнгэрийн орны аз жаргалыг элдэх болно.

Тиймээс эндээс биднийг санаж байх ёстой зүйл нь “Есүс” болон “Есүс Христ” гэдэг нэрэнд маш том ялгаа бий гэдгийг анхаарах хэрэгтэй юм. Матай1:21-д, “Түүнийг Хүү төрүүлэхэд, чи Түүнийг Есүс гэж нэрлэ. Учир нь Тэр Өөрийн ард түмнийг нүглээс нь аварна гэж хэлэв.” гэж айлдсан байдаг ба нөгөөтэйгүүр “Есүс” гэдэг нэр нь хүн төрөлхтөнийг гэм нүглээс нь аврах Аврагч хэмээн нэрлэгдэх хүнийг хэлж байгаа

юм. Нөгөө талаар, “Христ” гэдэг нь “Тослогдсон Нэгэн” утгатай Грек үг бөгөөд Аврагч болох болзуудыг төгс хангасан хүнийг хэлж байгаа билээ. Түүнчлэн Еврей хэлээр “Мессиа” гэдэг бол Солонгос болон Монголоор “Аврагч Эзэн”, эсвэл “Эзэн Есүс”, “Есүс Христ” гэх мэт нэрлэж дууддаг нь Өөрийн ард түмнийг нүглээс хэдийнээ аварсан Аврагч Эзэнийг хэлж байгаа билээ .

Тэгвэл Есүс хэзээ “Аврагч” болсон юм бэ? Энэ нь Есүс загалмайд цовдлогдсон үхсэний дараа буюу үхлийн эрх мэдлийг устгаж дахин амилсан учир бидний Аврагч болсон юм. Мөн “Есүс” гэдэг нэр нь загалмай дээр цовдлогдохоос өмнө Түүнийг дуудахад хэрэглэдэг нэр байсан бол загалмай дээр цовдуулж дахин амилсны дараа Түүнийг Есүс Христ гэж дуудвал зохих юм. Тийм ч учраас Түүний дагалдагч нар нь Түүнийг дахин амилсаны дараа зөвхөн Есүс хэмээн дуудахгүй Их Эзэн эсвэл Есүс Христ гэж дуудах болсон билээ (Үйлс 2:36, 3:6).

Энд маш чухал сүнслэг утга агуулагдаж байгаа юм.Бид Есүс болон Есүс Христ нэрийн ялгаа ба утга учрыг ойлгосноор авралын төлөвлөгөө төгс хэрэгжсэнийг мэдэж Есүс Христийн нэр дээр залбирахад өөрийн хүчээр боломжгүй ажлыг ч гэсэн Эзэн дотор боломжтой гэдэгт итгэн, итгэлээ гэрчилж залбирахад муу ёрын сүнс сатан айн чичирч зайлан оддог билээ.

4. Есүсийг бид Аврагчаар хүлээн авбал Ариун Сүнснийг авч, гэрэл дотор байна

Илчлэлт 3:20-д Есүс Эзэн, “Харагтун, Би үүдэн дээр зогсоод тошиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дуут сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно.” хэмээн айлдсан байдаг. Хэн ч гэсэн зүрх сэтгэлийн үүд хаалгаа нээж, Есүс Эзэнийг хүлээн авбал Эзэн тэдний гэм нүглүүдийг нь уучлан

(1 Иохан 1:7). Тэдэнтэй хамт байна гэж айлдсан билээ. Тийм болохоор зүрх сэтгэлийн үүдийг нээхийн тулд бид эхлээд бодол санааныхаа үүдийг нээх хэрэгтэй байдаг. Бурханы сургаалыг сонсох үед бид өөрсдийн бодол санаа ба мэдлэгтэйгээ уяалдуулан дүгнэлгүйгээр харин ч Түүний үгийг хүлээн зөвшөөрөн авах хэрэгтэй. Тэгсэн тохиолдолд л Бурхан бидэнд Ариун Сүнсээ илгээж, (Үйлс 2:38) Түүний үгээр амьдрах жинхэнэ итгэл ба хүч чадал итгэл найдварыг хүлээн авдаг.

Энэ нь өөрөөр хэлбэл ус болон Ариун Сүнсээр дахин төрөх ба ийнхүү дахин төрсөн хүн нь Бурханы үр хүүхэд хэмээн дуудагдаж, нэр нь тэнгэрийн орны Амийн номонд бичигдэн тэнгэрийн орны иргэншлийг хүлээн авдаг билээ. Энэ гээж дэлхий дээр дагаж мөрдөх ёстой хууль дүрмүүд байдаг шиг тэнгэрийн оронд ч гэсэн дагаж мөрдөх ёстой хууль дүрмүүд байдаг ба энэ хууль нь Бүхнийг Бүтээгч Эзэн, бидний Эцэг Бурханы сургаал үгс бөгөөд бид үүнийг дагаж мөрдөх хэрэгтэй билээ.Түүнчлэн бид гэрэл дотор амьдарвал муу ёрын сүнс сатаны уруу татлагад оролгүй тэнгэрийн оронд очих хүртлээ үргэлж Бурханы хайр энэрэл ивээл дотор хамгаалагдаж, ерөөл ба аз жаргалтай амьдардаг билээ.

Хайрт ах эгч дүү нар минь Бурхан бид нарт шудрага ёсны хуулийн дагуу итгэлээрээ аврал хүртэх үйл явц ба боломжыг гаргаж өгсөн бөгөөд энэ авралын төлөвлөгөө нь нууц дотор Бурханы ивээлээр болон Эзэний хайраар төгс биелсэн юм. Хайрын Бурхан одоо ч гэсэн сайхан сэтгэлт үр хүүхдүүдээ хайсаар байгаа бөгөөд үй олон хүмүүсийг авралын зам руу удирдаж байна.

Тиймээс эрхэм та Есүс Христийг хүлээн авч өөрийн амьдралдаа урин оруулж, итгэлээрээ нэгдэн дахин амилсан Эзэнтэй хамт тэнгэрийн оронд үүрд мөнхөд аз жаргалыг элдэн сайхан амьдархыг Эзэний нэрээр хүсэн өрөөе !



Помпеи хотоос ухан гаргасан археологийн эд баримт зүйлүүд ба зурган дээр театр, нарийн боовны дэлгүүр, зураг хөргүүд болон үзэсгэлэнт чимэглэлт газрууд.

Ромын Эзэнт Гүрний үзэсгэлэнт амралтын газар Помпейд юу болсон бэ?

Библи дээр Содом болон Гоморра, болон галт уулын дэлбэрэлтийн улмаас устгагдсан Помпей хот, Ромын эзэнт гүрэн, Түүнчлэн Инка болон Маяа соёл иргэншлийг үзвэл тэдний төгсгөл нь соёл иргэншил уналт ба ёс суртахууны эмх замбараагүй байдал нь дээд зэрэгтээ тулсан байсныг мэдэж болох юм.Өдөр хоног өнгөрөх тусам гэм нүгэл атгаг байдлаар дүүрч буй энэ үед, төрөл бүрийн гай гамшиг тохиолдож байгаагын учир юу болохыг ойлгож, үүнээс сургамж аван илүү ерөөлт итгэгч болохыг хүсье.

Өнө эртний хот болох Помпей нь Италийн өмнө зүгт Кампанна мужийн Напплесийн хойг дээр байрладаг байв. Одоо далайгаас алслагдсан газар боловч тэр үед Весувиу галт уул болон Сарно хэмээх мөрний эрэг дээр байрладаг боомт хот байв. Тус хот нь Ромын эзэнт гүрэн болон бусад олон орнуудад аж үйлдвэр болон худалдааны төв болон анхаарал татсан агуу гайхамшигт газар байсан бөгөөд Ромын баячууд хүрч ирэн амралтаа өнгөрөөдөг амралтын газар байв.

МЭ 79 оны Наймдугаар сарын 24-нд, Помпей болон Херкуланеум хотууд нь Весувиу галт уулын дэлбэрэлтийн нурманд аймшигтайгаар булагдан сөнөсөн билээ. Дээр дурьдсан галт уул Весувиу галт уулыг дэлбэрнэ гэдгийг огт таамаглаж чадахгүй байсан юм. Энэхүү аймшигт байгалийн гамшигийн тухай www.AllaboutHistory.org сайт дээр, Наймдугаар сарын оглооний арван цагын орчимд Весувиу галт уулын асар их хүчтэй галт уулын лавнууд цацагдан буун ирж тэр хавийг болон эргэн тойрныг бүрхсэн бөгөөд тэнгэрийн мандалд хорнод милл(30гаруй км) зайтай хол шидэгдэн цацагдана гэдгийг хэн ч төсөөлөөгүй байлаа. Мөөг мэт хэлбэртэй хүхэрт үүлс нь 24 мегатоннын хүчтэй задралт явагдсан бөгөөд энэ нь–Хиросимад болсон цөмийн дэлбэрэлтээс нэг мянга дахин хүчтэй—дэлбэрэлт үүсгэн нураан устгав. Газрын гүнийн магма нь дэвшлэн гарч, галт уулын нурмууд дууны хурднаас хоёр дахин хурдан цацагдан шидэгдэв.

Галт уулын дэлбэрэлтийн улмаас устгагдсан эртний Помпей хотын туурь

www.AllaboutHistory.org хэмээх сайт дээр өгүүлэхдээ, “ Помпей хот нь 4 метрийн өндөр чулуулаг болон галт уулын нурманд булагдсан бөгөөд үүний дараахан бороо хүртэл орж яг цемент шиг хатуурсан бөгөөд энэ бүх зүйл бий болоход 24 цаг ч болоогүй байгааг харж болно. 1549 онд Помпей хотын олдвор усан замын засварын үеэр Сарно голын туннелыг ухан бий болгохоос эхэлсэн ба түүнээс өмнө огт мартгадсан байсан ба анх нэг хэсэг олдвор илэрсэн бөгөөд энэ үеэс эхлэн малтлагын ажил эхэлсэн юм. Анхандаа энэ олдворыг Помпей хотынх гэж мэдээгүй бөгөөд эд хэрэглэл болон баримал хөшөө мэт хүн дүр төрхтэй хатууран чулуужсан эдгээр олдворууд нь эртний Помпей хотынх болохыг нотлогдсон юм. Мөн тэдний урлаг болон соёлын зүйлс нь хадгалагдан үлдсэн байдаг ба ханан дээр “Дэлхий ертөнцөд ямар ч зүйлс мөнхөд биш” хэмээн бичсэн байдаг. Одоо ч гэсэн уг олдворын хайгуулын ажил ба малтлагын ажил үргэлжилсээр байна.

Тус хотын малтлагын ажлын үеэр илэрсэн олдворуудыг харвал тухайн үеийн Ромын нийгмийн өдөр тутмын амьдрал болон соёл урлаг болон Ромын эзэнт гүрний шашин шүтлэгийг хүртэл олж мэдэхэд тусалсан билээ. Мөн энд галт уулын дэлбэрэлт нь тэдэн дээр гэнэт бууж ирснийг нотлох олдворууд ч олон байгааг харж болно. Тэдний илэж хэрэглэж байсан зүйлс талх, шарсан гахайн тоорой, мөнгөн зооснууд, бэх ба цаас гэх мэт тэр үеийн дүр төрх тэр чигээрээ хатууран үлдсэн байсан мөн цашилбал хүүхдээ тэвэрч буй эмэгтэй, эрдэнэсийн зүйл тас атгасан хүн, ямар нэгэн зүйл руу гараа сунгасан хүн, нэг гэрэ тойрон сууцгаасан хүмүүс, халуун уур ба хүхэрээс нүүрээ хамгаалах гээд хоёр гараараа нүүрээр хаасан хүн зэрэг тэр чигээрээ хатаж чулуужсан хүмүүсийг дүр төрхийг харахад аймшигтай байлаа. Тус хотын соёл урлагыг олж ирүүлсэн түүхэн дурсгалт зүйлсээ үзэхэд дотор нь усан оргилуур, зах зээлийн газар болон үсчин, зугаа цэнгээний театр, дэлгүүр, хананы зураг, нийтийн бие засах газар, маш олон чулуун замууд байгааг харж болно. Ханан дээр байгаа зургуудыг ажиглан судалж үзвэл шашин шүтлэг болон соёлын байдалд бэлгийн гаж буруу ойлголтууд маш их нөлөөлөн орсон байгааг харж болдог.

Библид дурдагдсан Содом ба Гоморрагийн мөхөл

Библи дээр Содом болон Гоморра 2 Петр 2:6-д, “хожмын бурхналаг бус хүмүүст жишээ болгохын тулд Содом ба Гоморрагийн хотуудыг үнсэн товрог болгосноор ялласан бол” хэмээн дурдан бичсэн байдаг ба Иуда 1:7-д. “Үүнчлэн Содом, Гоморра болоод эргэн тойрных нь хотууд элдэрийн нэгэн адил завхайралд автагдан, өөр гаж махан биеийн араас явсан тул мөнхийн галын шийтгэлд өртөхийн жишээ болдог юм.” гэж айлдсанчлан Содом ба Гоморра нь садар самуун байдал маш их автагдсан байсныг харж болно.

Тухайн үед Содом ба Гоморра жижигхэн голоор тусгаарлагдаж байсан ба хоорондоо чөлөөтэй ирж очих ба тэдний амьдралын дүр төрх соёл иргэншил бараг адилхан байсан бөгөөд Эхлэл 19-р бүлэгт үзвэл тэр хоёр хотын хүмүүс нь Бурханы өмнө үнэхээр жигшм садар самуун завхайран маш их гэм нүглүүдийг үйлдэцгээж байв. Тиймээс Содом Гоморра устгагдсан бөгөөд тэндээ хол зайтай орших Зоар хэмээх газар ч хэдийн тэдний гэм нүгэлд хутгалдсан байсыг харж болно.

Бурхан тэнгэрээс хүхэр болон галыг бороо мэт буулгаж тэр хотуудыг устгасан юм. Тэгээд ч зогсохгүй тэд хөнөөд бүхлээр нь бас хотод амьдарч байсан хамаг амьтан, газрын ургамал бүгдийг хөмрөн сүйрүүлсэн юм. (Эхлэл 19:24-25). Тэр нь хараагдсан газар болсон ба ямар ч амьд амьтан ургамал ургахгүй болсон байв. Одоо үед тэр газар нь Сөнөсөн тэнгисийн дор оршиж байдаг ба тэр хотуудын байршил нь Эзэний цэцэрлэг буюу Египетийн газар нутаг мэт харагддаг билээ. Энэ талаар (Эхлэл 13:10) дурдагдсан байдаг ба өнөө үед давст тэнгисийн усан доор байрладаг ба газрын гадаргуугаас 423 метрээс (1,388 feet) доор оршдог юм.

Бурханы шудрага ёсонд нийцүүлэн залбиран гүйх нь

Энэ галт шүүлт дундаас Лот ба түүний гэр бүлийнхэн аврагдсаны учир нь Бурхан тэдний авга ах Аврахамыг бодсоны эцэст тийм шийд гаргасан билээ. Зөвг Аврахам Лотыг үргэлж зүрх сэтгэлдээ өвөрлөн бодож байсан болохоор Лот аврагдах болсон юм. Хэдий тийм байсан ч Лот өөрөө энэ боломжыг ашиглаагүй байсан бол эцэстээ аврагдаж чадахгүй байх байсан юм.

Бурханы галт шүүлт яг эхлэхийн өмнөхөн Лот нь Содомд хурааж цуглуулсан өөрийн бүх эд хөрөнгөө орхин гэр бүлээ аваад хотыг орхин зугтсан юм . Тэрээр явахын өмнө түүний охидуудтай суух гэж байсан сүйт залуучуудад нь энэ тухай, галт шийтгэл ирэх болно гэдгийг хэлсэн боловч тэд нар ер хүлээн аваагүй юм. Мөн Лотын эхнэр нь түүнийг даган явах замдаа Бурханы эргэн харж болохгүй хэмээн айлдсан зарлигыг умартан тэр хотын зүг рүү эргэн харснаараа давсан багана болон хувирдаг билээ. Энэ нь дэлхийн зүйлсийг хахагүй учраас тийм болсон юм

Библид үзвэл өдөр ирэх тусам дайн дажин, өлсгөлөн, газар хөдлөлт нь дэлхийн өнцөг булан бүрт бий болохыг зөгнөж байгаа билээ. Ийм гай гамшигн эхлэл нь Эзэний дахин ирэлт нь ба дэлхий эцэс төгсгөлийг ойртож байгааг харуулж байна. Гэвч Эзэн шавь нартаа бүү ай гэж айлдсны учир юу юм бол?

Хайрын Бурхан бүх хүнд эцэс хүртэл нь авралын боломжыг өгч байдаг. Өөрөөр хэлбэл Ариун Сүнсний гайхамшигт хүчээр олон хүнийг авралын зам руу удирдаж, шинжлэх ухаан ба соёл иргэншил өндөр хөгжснөөс үүдэн гарах элдэв байгалийн гамшиг тохиолдох үед ч Бурханы шудрага ёсонд нийцүүлэн залбирвал энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой учраас юм. Түүнчлэн бидний туйлын зорилго болох тэнгэрийн оронд орох хүртлээ дэлхийн зүйлд хутгалдахгүй байхыг болон итгэлийн үйлсээ алдахгүй байж дэлхий ямар ч зүйлд авталгүйгээр зөвхөн Эзэнийг л хайрлахыг хүсэн өрөөе.

Мөргөлийн цаг		Залбирлын цаг		
Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч
Их мөргөл	Ням гариг 10: 30	Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзааа (Том хүний баг хариуцагч)
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40			
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00	Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00			
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30			
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30	Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)

Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С

Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.manmintv.org